



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 278

Улаанбаатар хот

Даатгалын байгууллагад аудит хийх  
эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.8, 2.10 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, ММНБИ-ийн хамтран хийсэн даатгалын байгууллагын аудитын чанарын хяналтын үр дүнг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.8.1, 2.8.2 дахь заалтуудыг зөрчсөн “Ситико-Аудит” компанийн даатгалын байгууллагад аудит хийх эрхийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.10.7 дахь заалтын шаардлагыг хангаагүй “СМД-Аудит” ХХК, “Санхүүч-Аудит” ХХК-ийн даатгалын байгууллагад аудит хийх эрхийг хүчингүй болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН